

БАТЛАВ.  
 "АВТОТЭЭВРИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ" ТӨҮГ-ЫН  
 ЗАХИРАЛ Б.ГҮРСОРОНЗОН

**МЭДЭЭЛЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭ  
 ХИЙЛГЭХ АЖЛЫН ДААЛГАВАР**  
 АТҮТ/20240203013

2024.12.05

1	Зорилго	"Автотээврийн үндэсний төв" ТӨҮГ-ын Мэдээллийн аюулгүй байдлын менежментийн тогтолцоог бүрдүүлж, ISO 27001:2022 стандартын шаардлагыг хангах, нэвтрүүлэх, кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ хийх
2	Хамрах хүрээ	"Автотээврийн үндэсний төв" ТӨҮГ
3	Дагаж мөрдөх хууль тогтоомж, дүрэм, журмууд	1. Кибер аюулгүй байдлын тухай хууль, кибер аюулгүй байдлыг хангах нийтлэг журам, төрийн болон албаны нууцын тухай хууль, Засгийн газрын 2018 оны "Төрийн мэдээллийн аюулгүй байдлыг хангах зарим арга хэмжээний тухай" 138 дугаар тогтоол, 2. Кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ хийх журам, аргачлал
4	Ажил үйлчилгээг хэрэгжүүлэх үе шат	1. Одоогийн нөхцөл байдлыг судалж дүн шинжилгээ хийх ISO 27001:2022 стандартын дагуу зөрүүний шинжилгээ хийх Байгууллагын бодлогын баримт бичигт дүн шинжилгээ хийх Сервер, систем, өгөгдлийн сангуудад ахисан түвшний нэвтрэх шалгалт хийх Ажлын хэсгийн нарийвчилсан төлөвлөгөө гаргаж батлуулах Ажлын хэсгийн гишүүдэд мэргэжил, арга зүйн сургалт хийх 2. Шинжилгээний үндсэн дээр ISO стандарт нэвтрүүлэхэд шаардлагатай нөөцийг тодорхойлж төлөвлөгөө боловсруулж батлуулах МАБ –ын үйл явцыг тодорхойлох, зураглал хийх МАБМТ –ны хамрах хүрээг тодорхойлох МАБМТ –ны бодлого, зорилтыг тодорхойлох МАБ эрсдэлийг тодорхойлж үнэлгээ хийх, хариу арга хэмжээ авах ажиллах МАБМТ –ны хүрээнд шаардлагатай бодлого, журам, зааврыг шинээр эсвэл шинэчилж боловсруулан батлуулах 3. ISO 27001:2022 стандарт нэвтрүүлэх Нийт ажилтнуудад МАБМТ –ны талаарх мэдлэг ойлголтыг дээшлүүлэх сургалт зохион байгуулах Кибер аюулгүй байдлын эрсдэлийн мэдлэг, ойлголтыг дээшлүүлэх сургалтыг нийт ажилчдад сургалт зохион байгуулах 4. ISO 27001:2022 стандарт хэрэгжүүлэх МАБМТ –ны хүрээнд шинээр эсвэл шинэчилж гаргасан бодлого, журам, зааврыг үе шаттайгаар хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах МАБМТ –ны хүрээнд сервер, систем, өгөгдлийн сангуудын эмзэг байдлын эрсдэлийг бууруулах, арилгах 5. Хэрэгжилтэд баталгаа гаргаж хамтран ажиллах

		<p>1 жилийн баталгаат хугацаанд систем, серверүүдийг тодорхой давтамжийн дагуу мэдээллийн аюулгүй байдлыг хянаж тайлагнан ажиллана</p> <p>6. Сургалт</p> <p>"АТҮТ" ТӨҮГ –ын нийт ажилчдад</p> <p>Мэдээллийн аюулгүй байдлын чиглэлээр 2 удаа</p> <p>ISO 27001 стандарт 1 удаа</p> <p>Кибер аюулгүй байдлын тухай хууль, журмын сургалт 2 удаа</p> <p>Удирдлагын багт</p> <p>Мэдээллийн аюулгүй байдлын менежментийн тогтолцоо</p> <p>Мэдээллийн аюулгүй байдлын эрсдэлийн удирдлага</p>
5	Ажил үйлчилгээний онцгой нөхцөл	Гэрээний хугацаанд кибер халдлага, гэнэтийн эрсдэл учирсан тохиолдолд хариу арга хэмжээ авч, асуудлыг шийдвэрлэх төлөвлөгөө боловсруулж төлөвлөгөөний дагуу эрсдэлийг бууруулах болон арилгаж ажиллана.
6	Ажил үйлчилгээг гүйцэтгэгчид тавигдах шаардлага	ISO27001 стандартын олон улсын баталгаажуулалт хийдэг гадаад түнштэй хамтран ажилладаг байх Сургалт зөвлөгөөний тараах материал, дүрс бүхий хичээл, мэдээллийн хуудас, ном, гарын авлагаар хангах боломжтой байх
7	Зөвшилцөх байгууллага	Тагнуулын ерөнхий газрын харьяа Мэдээллийн аюулгүй байдлын газар